

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЗАМ, ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ХАРЬЯА ДАЛАЙН ЗАХИРГААНЫ 2018 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: САГ-2019/292/СТА-ТӨҮГ

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1 Оршил.....	4
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин.....	5
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл	8
2.8.2 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал...	9
2.10 Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11 Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3. Менежментийн захидал.....	11
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	12

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ДАЛАЙН ЗАХИРГААНЫ ДАРГА
С.ТҮВШИНТӨР ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.03.15 № 06/486
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Зам, тээвэр хөгжлийн яамны харьяа Далайн захиргааны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Зам, тээвэр хөгжлийн яамны харьяа Далайн захиргааны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Зам, тээвэр хөгжлийн яамны харьяа Далайн захиргааны 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Зам, тээвэр хөгжлийн яамны харьяа Далайн захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Далайн захиргааны дарга С.Түвшинтөр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох валютын ханшийн зөрүүтэй холбоотой зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Зам, тээвэр хөгжлийн яамны харьяа Далайн захиргааны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, тодруулгад Үндэсний аудитын газартай байгуулсан гурвалсан гэрээг үндэслэн аудит хийлээ.

Зам, тээвэр хөгжлийн яамны харьяа Далайн захиргааны 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Далайн захиргааны удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС болон холбогдох бусад стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 25-наас 2019 оны 3 дугаар сарын 13-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Монголиан Бизнес Рейтинг Аудит” ХХК-ийн ерөнхий захирал Д.Түмэнжаргал хянан удирдаж, аудитор Л.Хаш-Эрдэнэ, аудиторын туслах Д.Энхжаргал нарын бүрэлдэхүүнтэй баг гүйцэтгэж, чанарын хяналтын менежер Р.Цанжидмаа хяналт тавьж хэрэгжүүлэв.

Зам, тээвэр хөгжлийн яамны харьяа Далайн захиргааны 2018 оны санхүүгийн тайланг “Монголиан Бизнес Рейтинг Аудит” ХХК-д 2019 оны 1 дугаар сарын 17-ны өдрийн 1/12 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Зам, тээвэр хөгжлийн яамны харьяа Далайн захиргааны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Зам, тээвэр хөгжлийн яамны харьяа Далайн захиргаа нь далайн тээврийн салбарын эрх зүйн орчин, хяналтын системийг боловсронгуй болгох, олон улсын стандартад нийцүүлэх, далайн тээврийн салбарт тэргүүлэгч улсуудтай хамтран далайн тээвэр эрхлэх боломжийг эрэлхийлэх, Нэгдсэн үндэсний байгууллагын далайн гарцгүй хөгжиж буй орнуудын олон улсын судалгааны төвтэй хамтран ажиллах, усан замын тээврийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, сурталчлах, байгаль орчинд ээлтэй усан замын тээврийг хөгжүүлэх, аюулгүй байдлыг хангах” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Далайн тээврийн олон улсын гэрээ, конвенци болон дотоодын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, далайн тээврийн стратеги, бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохицуулах, далайн чиглэлээр боловсон хүчин бэлтгэх, хөлөг онгоц бүртгэх, боомт ашиглах, усан замын тээврийн бүртгэл хийх, хяналт тавих чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Зам, тээвэр хөгжлийн яамны харьяа Далайн захиргааны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Зам, тээвэр хөгжлийн яамны харьяа Далайн захиргааны удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Далайн эрх зүйн байдлын тухай хууль
- Их далай ашиглах талаар авах зарим арга хэмжээний тухай хууль
- Далай ашиглах тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчны томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй бөгөөд Нийгмийн даатгалын тухай хуульд нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд татварын хөнгөлөлтөд өөрчлөлт орсныг хэрэгжүүлж ажилласан байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус байгууллагын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Зам, тээвэр хөгжлийн яамны харьяа Далайн захиргаа санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Зам, тээвэр хөгжлийн яамны харьяа Далайн захиргаа нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ “Ординат” ХХК-ийн боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн “Юникус” санхүүгийн програм хангамжийг ашигладаг байна.

Зам, тээвэр хөгжлийн яамны харьяа Далайн захиргааны дотоод хяналтын эрсдлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Зам, тээвэр хөгжлийн яамны харьяа Далайн захиргааны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь тус байгууллага нь өөрийн орлогоор санхүүжиж, батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг, улсын төсөвт орлого төвлөрүүлдэггүй, нийт зардал нь тайлант хугацааны үйл ажиллагааг төлөөлж чадахуйц суурь үзүүлэлт гэж үзсэнтэй холбоотой юм.

Зам, тээвэр хөгжлийн яамны харьяа Далайн захиргаа 2018 оны нийт зардал 1,042.3 сая төгрөг бөгөөд түүний 1.0 хувь болох 10.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1.0 хувиар тооцсон нь тухайн байгууллагын аудитын чиглэлүүдэд үзүүлж болзошгүй эрсдэлийг харгалзан үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.
Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	(сая төгрөгөөр)
				Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	0.06	
2	Албан шаардлага	1	1.9	
3	Төлбөрийн акт тогтоосон	1	0.1	
	Дүн	3	2.1	

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.2.1.1 Балансын данстай холбоотой асуудал

Томилолтын урьдчилгааг хаахдаа анхан шатны баримт, томилолтын ажлын үр дүнгийн тайлан зэргийг хянан, баталгаажуулаагүйгээс томилолтын 0.14 сая төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь хэмжилт, үнэлгээ, үнэн зөв байдал, иж бүрэн, зэрэг батламж мэдэгдэлтэй нийцээгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоох

2.8.2.1.2 Балансын данстай холбоотой асуудал

Бараа материалын орлого, зарцуулалтын тайлан гаргаагүй, тооллого хийж тооцоо бодоогүй, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ бүртгэсэн зэрэг зөрчлүүд илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын

бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтуудыг зөрчсөн ба хэмжилт, үнэлгээ, иж бүрэн, үнэн зөв, оршин байх зэрэг батламж мэдэглүүдтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Сингапур дахь "Монголын хөлөг онгоцны бүртгэл" ХК-аас тус байгууллагаар дамжин, Зам тээвэр, хөгжлийн яаманд төвлөрүүлж байгаа хөрөнгийн эх үүсвэрийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Зам тээвэр, хөгжлийн яамны харьяа Далайн захиргаа чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 7 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 1,897.0 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,511.7 сая төгрөг буюу 79.7 хувьтай байгаа нь 385.3 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласнаас шалтгаалжээ. Үүнд: цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 115.5 сая, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 13.3 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 4.7 сая, хангамж бараа материалын зардал 13.6 сая, эд хогшил, урсгал засварын зардал 9.7 сая, бусад урсгал шилжүүлэг 8.5 сая, хөрөнгө оруулалтын зардал 554.9 сая төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Төсвийн орлогыг задалж үзвэл үндсэн үйл ажиллагааны орлого 867.0 сая, татварын бус орлого 116.4 сая, үндсэн бус үйл ажиллагааны орлого буюу хөлөг онгоцны бүртгэлийн орлого 520.6 сая, хөрөнгө оруулалтын орлого 32.2 сая, нийт 1,536.3 сая төгрөгийн орлоготой байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Зам, тээвэр хөгжлийн яамны харьяа Далайн захиргаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны тухай хуульд заасны дагуу төрийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор гаргасан удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих тогтолцоог хуулийн дагуу хангасан талаарх

мэдээллийг шалгаж үзэхэд хуульд заасан хугацаанд жил улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг www.shilendans.gov.mn сайтад байршуулж толилуулсан байна.

Шилэн дансны нэгдсэн цахим системд 2018 онд 13 төрлийн мэдээллийг жил, улирал, сар, тухай бүрийн давтамжтайгаар 146 удаа мэдээлэхээс 143 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроон толилуулсан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийн биелэлт 70.0 хувьтай буюу бараа материалын анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулалт гарсан зөрчил дахин давтан гарч байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Зам, тээвэр хөгжлийн яамны харьяа Далайн захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зам, тээвэр хөгжлийн яамны харьяа Далайн захиргаа 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Зам, тээвэр хөгжлийн яамны харьяа Далайн захиргааны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Балансын данстай холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт

Валютын ханшийн бодит бус зөрүүг буруу тооцоолж, мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 0.06 сая төгрөгөөр дутуу тайлагнасан нь Монгол банкны 2010 оны 12 дугаар сарын 7-ны өдрөөс эхлэн “Тухайн өдрийн хаалтын ханш”-ийг зарлаж байгаа бөгөөд энэ ханшийг Монгол банкнаас зарласан дараа өдрийн ханш гэж тооцдог журмыг зөрчсөн ба үнэн зөв байх, хэмжилт, үнэлгээ оршин байх зэрэг батламж мэдэглүүдтэй нийцэхгүй байна.

3.1.2. Эрсдэл

- Санхүүгийн тайлан буруу гарах
- Хууль, тогтоомж, заавар журам зөрчигдөх

3.1.3. Өгсөн зөвлөмж

Монгол банкнаас зарласан дараа өдрийн ханш гэж тооцдог журмыг хэрэгжүүлж, үнэн зөв бүртгэж, тайлагнах.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг 2019 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 1/56 дугаар бүхий албан бичиг ирүүлсэн.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	2017 оны 12 сарын31	2018 оны 12 сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	701,270,351.18	989,975,195.33
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	550,333,913.92	574,861,537.72
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	550,333,913.92	574,861,537.72
3121	Төгрөг	13,611,540.76	355,688,542.94
31213	Арилжааны банк дахь харилцах	13,611,540.76	355,688,542.94
3122	Гадаад валют	536,722,373.16	219,172,994.78
31223	Арилжааны банк дахь харилцах	536,722,373.16	219,172,994.78
33	АВЛАГА	92,289,611.26	32,610.46
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	32,610.46	32,610.46
335	Бусад авлага	92,257,000.80	-
3351	Байгууллагаас авах авлага	92,257,000.80	-
34	УРЬДЧИЛГАА	19,782,000.00	367,224,643.30
34600	Урьдчилж гарсан зардал	282,000.00	282,000.00
3471	Урьдчилгаа тооцоо	19,500,000.00	366,942,643.30
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	19,500,000.00	366,942,643.30
35	БАРАА МАТЕРИАЛ	38,864,826.00	47,856,403.85
354	Хангамжийн материал	38,864,826.00	47,856,403.85
35410	Бичиг хэргийн материал	3,220,000.00	4,057,797.85
35420	Аж ахуйн материал	34,410,032.00	42,195,612.00
35470	Бусад хангамжийн материал	1,234,794.00	1,602,994.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	543,901,989.15	613,746,228.49
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	190,192,000.00	190,192,000.00
373	Урт хугацаат зээл	190,192,000.00	190,192,000.00
37330	Урт хугацаат хөрөнгө оруулалт-зам, гүүр	190,192,000.00	190,192,000.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	353,709,989.15	423,554,228.49
391	Газар		
392	Биет хөрөнгө	352,389,989.15	411,106,228.49
39201	Барилга, байгууламж, орон сууц	138,573,427.00	52,895,760.04
39202	Хуримтлагдсан элэгдэл	40,325,493.12	-
39203	Авто-тээврийн хэрэгсэл	318,556,224.50	454,840,201.74
39204	Хуримтлагдсан элэгдэл	106,324,449.63	146,528,405.43
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	71,213,486.01	86,017,316.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	42,206,011.47	52,619,717.19
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,277,769.00	31,742,169.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	12,374,963.14	15,241,095.68
393	Биет бус хөрөнгө	1,320,000.00	12,448,000.00
39301	Програм хангамж	5,460,000.00	5,460,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	4,140,000.00	5,460,000.00

Зам тээвэр, хөгжлийн яамны харьяа Далайн захиргааны 2018 оны
санхүүгийн тайлангийн аудит

39303	Бусад биет бус хөрөнгө	-	12,448,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,245,172,340.33</u>	<u>1,603,721,423.82</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,245,172,340.33</u>	<u>1,603,721,423.82</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,245,172,340.33	1,603,721,423.82
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	218,716,305.84	231,164,305.84
51101	Өмч:- төрийн	218,716,305.84	218,716,305.84
51106	Эздийн өмчийн бусад хэсэг		12,448,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,026,456,034.49	1,372,494,657.98
51210	Өмнөх үеийн үр дүн	1,026,456,034.49	1,026,456,034.49
51220	Тайлант үеийн үр дүн	-	346,038,623.49
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	62,460.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,245,172,340.33</u>	<u>1,603,721,423.82</u>

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,715,210,335.16	1,403,803,961.32
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,715,210,335.16	1,403,803,961.32
120	Нийтлэг татварын бус орлого	1,715,210,335.16	1,403,803,961.32
120001	Хувьцааны ногдол ашиг	494,468,860.98	
120002	Хүүгийн орлого	5,952,969.85	10,988,815.59
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,209,570,168.33	1,387,653,849.73
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	745,678,444.43	867,075,669.53
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	463,891,723.90	520,578,180.20
120009	Бусад орлого	5,218,336.00	5,161,296.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	862,386,061.38	1,042,307,036.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	862,386,061.38	1,042,307,036.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	672,386,061.38	833,307,036.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	37,4146,951.67	436,251,750.34
210101	Үндсэн цалин	326,956,262.10	364,619,797.69
210102	Нэмэгдэл	31,006,689.57	53512452.65
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,184,000.00	18,119,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,441,335.76	52,673,158.83
210201	Тэтгэврийн даатгал	26,765,806.48	35,634,540.02
210202	Тэтгэмжийн даатгал	3,682,912.76	4,384,117.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,293,689.82	3,508,143.55
210204	Ажилгүйдлийн даатгал	699,902.56	831,487.03
210205	Эрүүл мэндийн даатгал	6,999,024.14	8,314,870.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,859,310.00	42,757,200.00
210304	Байрны түрээс	30,859,310.00	42,757,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,627,774.04	26,143,150.21
210401	Бичиг хэрэг	2,341,940.00	2,183,582.15
210402	Тээвэр, шатахуун	16,165,055.90	16,134,059.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,120,778.14	7,825,509.06
2105	Нормативт зардал	2,030,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,030,000.00	
2107	Томилолт, зочны зардал	57,918,380.00	128287,307.20
210701	Гадаад албан томилолт	42,996,631.00	117,829,927.20
210702	Дотоод албан томилолт	12,513,350.00	9,667,380.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,408,399.00	790,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	137,624.65	132,530.35
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	137,624.65	132,530.35
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	143,224,685.26	147,061,939.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	105,012,188.24	86,849,540.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	38,212,497.02	60,212,399.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	190,000,000.00	209,000,000.00

Зам тээвэр, хөгжлийн яамны харьяа Далайн захиргааны 2018 оны
санхүүгийн тайлангийн аудит

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	190,000,000.00	209,000,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	190,000,000.00	209,000,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	852,824,273.78	361,496,924.89
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	8,989,697.71	32,156,551.46
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	8,989,697.71	32,156,551.46
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	17,875,584.39	47,614,852.86
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	17,875,584.39	7,608,824.46
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал		40,006,028.40
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-8,885,886.68	-15458301.40
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	843,938,387.10	346,038,623.49

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-		-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-			-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-		-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-		-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-		-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-		-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-		-	-
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	218,716,305.84		1,026,456,034.49	1,245,172,340.33
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	218,716,305.84		1,026,456,034.49	1,245,172,340.33
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-		-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	218,716,305.84		1,026,456,034.49	1,245,172,340.33
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	12,448,000.00		-	12,448,000.00
D05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	62,460,00	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-		-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-		-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-		346,038,623.49	346,038,623.49
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	243,612,305.84	62,460.00	1,372,494,657.98	1,616,106,963.82

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,727,144,761.16	1,517,656,424.32
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,714,856,766.16	1,504,080,354.32
120	Нийтлэг татварын бус орлого	1,714,856,766.16	1,504,080,354.32
120001	Хувьцааны ногдол ашиг	494,468,860.98	0.00
120002	Хүүгийн орлого	5,952,969.85	10,988,815.59
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,209,570,168.33	1,387,653,849.73
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	745,678,444.43	867,075,669.53
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	463,891,723.90	520,578,180.20
120009	Бусад орлого	4,864,767.00	105,437,689.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	12,287,995.00	13,576,070.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	12,287,995.00	13,576,070.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	12,287,995.00	13,576,070.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>941,620,154.12</u>	<u>1,360,124,320.28</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>941,620,154.12</u>	<u>1,360,124,320.28</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	728,319,507.12	1,119,016,250.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	373,606,351.67	434,259,854.42
210101	Үндсэн цалин	333,220,646.67	367,855,749.16
210102	Нэмэгдэл	24,201,705.00	48,284,605.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,184,000.00	18,119,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,441,335.76	52,673,158.95
210201	Тэтгэврийн даатгал	41,441,335.76	52,673,158.95
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,334,810.00	42,531,700.00
210304	Байрны түрээс	30,334,810.00	42,531,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,256,774.04	27,067,848.06
210401	Бичиг хэрэг	2,330,940.00	3,021,380.00
210402	Тээвэр, шатахуун	15,107,155.90	15,762,059.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,770,678.14	8,064,409.06
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,800.00	220,000.00
2107	Томилолт, зочны зардал	57,367,411.00	137,533,008.20
210701	Гадаад албан томилолт	43,086,862.00	125,638,628.20
210702	Дотоод албан томилолт	11,775,350.00	11,104,380.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,505,199.00	790,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	203,312,824.65	424,950,680.65
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	182,230,630.00	423,358,516.30
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,000,000.00

Зам тээвэр, хөгжлийн яамны харьяа Далайн захиргааны 2018 оны
санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ	0.00	77,220.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	298,370.00	354,214.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	146,200.00	20,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	19,000,000.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	137,624.65	140,730.35
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	213,300,647.00	241,108,070.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,300,647.00	32,108,070.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	12,287,995.00	13,576,070.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,367,652.00	117,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,350,000.00	14,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,295,000.00	4,015,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	190,000,000.00	209,000,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	190,000,000.00	209,000,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>785,524,607.04</u>	<u>157,532,104.04</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	8,989,697.71	<u>32,156,551.46</u>
145001	Валютын ханшийн зөрүү	8,989,697.71	<u>32,156,551.46</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	272,058,230.00	157,552,207.24
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	272,058,230.00	157,552,207.24
2200	Дотоод эх үүсвэрээр	272,058,230.00	157,552,207.24
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	272,058,230.00	157,552,207.24
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-280,944,116.68</u>	<u>-133,004,480.24</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>-263,068,532.29</u>	<u>-125,395,655.78</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-17,875,584.39	-7,608,824.46
25	ГАДААД ВАЛЮТЫН ХАНШНЫ ЗӨРҮҮ	-17,875,584.39	-7,608,824.46
250001	Гадаад валютын ханшны зөрүү	-17,875,584.39	-7,608,824.46
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	504,580,490.36	24,527,623.80
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	45,753,423.56	550,333,913.92
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	550,333,913.92	574,861,537.72

**Зам тээвэр, хөгжлийн яамны харьяа Далайн захиргааны 2018 оны
санхүүгийн тайлангийн аудит**

4.5 Аудит хийсэн Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн гүйцэтгэл
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Д/Д	Үзүүлэлтүүд	Х/н	2017 оны гүйцэтгэл	2018 оны		Харьцуулалт			
				төлөвлөгөө	Гүйцэтгэл	төлөвлөгөөтэй		өмнөх оноос	
						тоо	хувь	тоо	хувь
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	м.төг	1,714,856.50	1,896,991.60	1,504,080.10	-392911.50	79.3	(210,776.40)	87.71
Үүнээс	Үндсэн үйл ажиллагааны орлого	м.төг	745,678.40	1,893,991.60	867,075.60	-1026916.00	45.8	121,397.20	116.28
	Туслах үйл ажиллагааны орлого	м.төг	463,891.70		520,578.10	520578.10	-	56,686.40	112.22
	Хувьцааны ногдол ашиг	м.төг	494,468.80			0.00	-	(494,468.80)	0.00
	Хүүгийн орлого	м.төг	5,952.90		10,988.80	10988.80	-	5,035.90	184.60
	Бусад орлого	м.төг	4,864.70	3,000.00	105,437.60	102437.60	3514.6	100,572.90	2167.40
	2	Нийт орлого	м.төг	1,714,856.50	1,896,991.60	1,504,080.10	-392911.50	79.3	(210,776.40)
Үүнээс	Үндсэн үйл ажиллагааны орлого	м.төг	745,678.40	1,893,991.60	867,075.60	-1026916.00	45.8	121,397.20	116.28
	Туслах үйл ажиллагааны орлого	м.төг	463,891.70		520,578.10	520578.10	-	56,686.40	112.22
	Хувьцааны ногдол ашиг	м.төг	494,468.80			0.00	-	(494,468.80)	0.00
	Хүүгийн орлого	м.төг	5,952.90		10,988.80				
	Бусад орлого	м.төг	4,864.70	3,000.00	105,437.60				
	3	Нийт зардал	м.төг	1,508,724.60	1,041,085.00	1,369,534.10	328449.10	131.5	(139,190.50)
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	862,386.00	975,535.90	632,083.20	-343452.70	64.8	(230,302.80)	73.29
5	Цэвэр ашиг /алдагдал/	м.төг	550,333.90		574,861.50	574861.50	-	24,527.60	104.46
6	Төсвийн төлбөрт нийт дүн	м.төг	249,722.50	249,722.50	53027.3	-196695.20	21.2	(196,695.20)	21.23
	в/ НДШ	м.төг	41,441.30	67,977.00	52,673.10	-15303.90	77.5	11,231.80	127.10
	ё/ Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	115.50	1,350.00	354.20	-995.80	26.2	238.70	306.67
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	27.00	27.00	27.0	0.00	100.0	-	100.00
9	Нийт цалингийн сан	м.төг	333,220.60	549,808.00	374,146.90	-175661.10	68.1	40,926.30	112.28
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	1,028.46	1,696.94	1,154.77	-542.16	68.1	126.32	112.28
11	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	м.төг	1.00	1.00	1.00	0.00	100.0	-	100.00
12	Хөрөнгө оруулалт	м.төг	235,627.50	712,455.70	611,703.40	-100752.30	85.9	376,075.90	0.00
13	Нийт авлага	м.төг	92,289.60		32.61	32.61	-	(92,256.99)	0.04

1.Хавсралт

5.1 Зам, тээврийн хөгжлийн харьяа Далайн захиргааны зөрчлийн нэгтгэл

№	Аудитын зорилт, чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны		
					Нэр	Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5	9	10
1	Балансын данстай холбоотой асуудал	1	Валютын ханшийн бодит бус зөрүүг буруу тооцоолж, мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 63.8 мянган төгрөгөөр дутуу бүртгэж тайлагнасан.	0.06	Зөвлөмж өгөх	Далайн захиргааны дарга	С.Түвшинтөр
2	Балансын данстай холбоотой асуудал	1	Бараа материалын орлого, зарцуулалтын тайлан гаргаагүй, тооллого хийж тооцоо бодоогүй, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ бүртгэсэн.	1.90	Албан шаардлага өгөх	Далайн захиргааны дарга	С.Түвшинтөр
3	Балансын данстай холбоотой асуудал	1	Томилолтын урьдчилгааг хаахдаа анхан шатны баримт, томилолтын ажлын үр дүнгийн тайлан зэргийг хянан, баталгаажуулаагүйгээс томилолтын 0.14 сая төгрөгийг илүү олгосон байна.	0.1	Төлбөрийн акт тавих	Далайн захиргааны дарга	С.Түвшинтөр
дүн				2.1			

